



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Эрдэнэбулган сум

Зөвлөмж хүргүүлэх тухай

Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн Татварын газрын 2024, 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаа, татварын орлогын бүрдүүлэлт, тайлагналд хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцсэн Дотоод аудитын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрт үндэслэн дараах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсүгэй.

Аймгийн Татварын газрын дарга (Б.Эрдэнэбилэг)-д:

"Агаарын бохирдлын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасан төлбөрийн хэмжээг тогтоох аймгийн ИТХ-ын тогтоолын төслийг боловсруулж хянуулах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд улсын байцаагчийн тогтоосон акт, албан шаардлагын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөгөө гаргаж биелүүлэх, үр дүнг тайлагнах;

Аймгийн Цагдаагийн газрын дарга (О.Түмэнбаяр)-д:

Галт зэвсгийн тооллого, бүртгэл хөдөлгөөний баталгаажуулсан тоон мэдээг Татварын газарт хүргүүлэх, галт зэвсэг эзэмшигч шилжих тохиолдол бүрд татварын тооцоог хийж дуусгасны дараа бүртгэлээс хасах, шилжин очсон нутаг дэвсгэр хариуцсан албан хаагч хуулийн хугацаанд нэгдсэн мэдээллийн системд бүртгэж, Татварын газарт шуурхай мэдээлж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг тайлагнах;

Орхон Чулуут голын сав газрын захиргааны дарга (Ч.Отгонбаатар)-д:

Ус бохирдуулсны төлбөр"-ийн ногдуулалт, хаягдал усны мэдээллийг хуульд заасан хугацаанд Татварын газарт ирүүлж, тулган баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнах;

Аймгийн Байгаль орчны газрын дарга (Д.Батдорж)-д:

Усны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд Татварын газарт ирүүлж, тулган баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнах;

Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт:

Тухайн суманд дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа явуулж, агаар бохирдуулж байгаа суурин эх үүсвэрийн судалгаа мэдээллийг хуульд заасан хугацаанд баталгаажуулан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд ирүүлж нэгтгүүлэх;

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Булганбаатар)-д:

Сумдаас ирүүлсэн агаар бохирдуулж байгаа суурин эх үүсвэрийн судалгаа мэдээллийг нэгтгэж гаргасан тооцооллыг Татварын газарт хүргүүлж баталгаажуулах, үр дүнг тайлагнах;

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг улирал бүр, эцсийн үр дүнг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор тайлагнахыг дээрх байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан биелэлт үр дүнг Дотоод аудитын хороонд танилцуулахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (Д.Нэргүйбаатар)-д үүрэг болгосугай.

ХОРООНЫ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД